# 11- р сар

I. Төсвийн орлого
II. Төсвийн орлого, /сумаар/
III. Төсвийн зарлага
IV. Банкны кассын орлого зарлага, зээл хадгаламж
V. Ажил хайгч иргэд
VI. Ажлын байрны зуучлал
VII. Нийгмийн халамжийн сангийн үзүүлэлт
VIII. Нийгмийн даатгалын орлого
IX. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага
X. Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо
XI. Хүн амын  ердийн хөдөлгөөн, хүүхдийн эндэгдэл
XII. Эрүүл мэндийн үйл ажиллагааны үзүүлэлтүүд
XIII. Хэрэглээний үнийн индекс
XIV. Аж үйлдвэр
XV. Аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүн
XVI. Хөдөө аж ахуйн үнэ
XVII. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнэ тариф
XVIII. Гэмт хэрэг
XIX. Гэмт хэрэг зөрчил  (сумдаар)

**Аймгийн нийгэм, эдийн засгийн байдал**
**(2019 оны 11 сарын байдлаар)**

## I.Төсвийн орлого

Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээгээр 2019 оны 11 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 113.7 хувьтай буюу 7045.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна улсын төвлөрсөн төсөвт оруулбал зохих орлогын төлөвлөгөө 110.8 хувьтай буюу 1990.0 сая төгрөгийн орлогыг улсын төвлөрсөн төсөвт оруулаад байна. Улсын болон орон нутгийн төсөвт нийт дүнгээр 9035.4 сая төгрөгийн орлого оруулж, аймгийн дүнгээр орлогын төлөвлөгөөний биелэлт 113.1 хувьтай байна.
Тусламжийн орлогыг оруулан тооцсоноор аймгийн хэмжээний нийт орлого ба тусламж 40133.2 сая төгрөг болж, төлөвлөгөөний биелэлт 101.8 хувьтай байна. Орон нутгийн төсөвт улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 8906.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 21205.9 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2824.9 сая төгрөг, хандив тусламжаас 150.7 сая төгрөг нийт 33087.9 сая төгрөгийн тусламжийн орлого орсон байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөгөө Баянжаргалан, Хулд, Сайхан-Овоо, Сайнцагаан сумд 0.9-46 хувиар буюу 1.1-275.4 сая төгрөгөөр тасалдуулсан бол бусад сумд 3.3-162.8 хувиар буюу 3.1-475.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

## II.Төсвийн зарлага

2019 оны 11 сарын байдлаар орон нутгийн төсвийн байгууллагын зардлын дүн 36413.9 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 8.2 хувиар өссөн байна. Зардлын төрлөөр авч үзвэл цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал 20644.8 сая төгрөг болж нийт зардлын 56.7 хувийг эзэлж байна. Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл өмнөх оноос 28.8 хувиар өсч 2580.1 сая төгрөг болжээ. Тухайн сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулбал бусад урсгал шилжүүлэг 89.9 хувиар буурч 440.0 сая төгрөг болсон

бол бусад бүх зардал 0.2-106.9 хувиар буюу 5.5-741.7 сая төгрөгөөр өссөн байна.

## III.Банк

Банкны зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар өсч 118053.2 сая төгрөг болжээ. Үүнээс анхаарал хандуулах зээл 1483.5 сая төгрөг, чанаргүй зээл 1260.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өмнөх оны мөн үеэс анхаарал хандуулах зээл 118.7 хувь, чанаргүй зээл 20.8 хувиар тус тус нэмэгдсэн байна. Нийт зээлийн үлдэгдлийн 2.3 хувийг анхаарал хандуулах ба чанаргүй зээл эзэлж байна. Нийт хадгаламж өмнөх оны мөн үеэс 27.7 хувиар өсч 64686.7 сая төгрөг болов.

## IV.Бүртгэлтэй ажилгүйчүүд

2019 оны 11 сарын байдлаар аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт бүртгэлтэй, ажил хайж байгаа 502 хүн бүртгэгдсэн нь өмнөх сартай харьцуулахад 3.0 хувиар буурсан байна. Нийт ажилгүйчүүдийн 48.8 хувь буюу 245 хүн нь эмэгтэйчүүд байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны 10000 хүнд 165 ажил хайгч иргэн ногдож байхад Говь-Угтаал 492, Цагаандэлгэр 465, Өндөршил 423, Сайхан-Овоо-229, Гурвансайхан 205, Луус 261 байгаа нь аймгийн дунджаас дээгүүр байна.

## V.Ажлын байрны зуучлал

ХХҮГазрын 2019 оны 11 сарын мэдээгээр нийт 622 хүн ажлын байранд зуучлагдсан нь өмнөх оны мөн үеэс 8 хүнээр өссөн байна. Ажлын байранд зуучлагдсан иргэдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд уул уурхайн салбарт 15.6 хувь, хөдөө аж ахуйн салбарт 14.1 хувь, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 24.3 хувь, боловсролын салбарт 8.8 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбарт 1.1 хувь, цахилгаан эрчим хүчний салбарт 0.6 хувь, урлаг үзвэр тоглоомын салбарт 2.1 хувь, үйлчилгээний бусад салбарт 19.3 хувь, хүний эрүүл мэнд нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт 3.5 хувь зуучлагдсан байна. Ажлын байранд

зуучлагдсан иргэдийн 288 нь буюу 46.3 хувь нь эмэгтэйчүүд байна.

## VI. Нийгмийн халамж

2019 оны эхний 11 сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас 19075 хүнд 6214.9 сая төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, халамжийг олгосон байна. Нийт тэтгэвэр тэтгэмж авагчдын 24.4% буюу 4564 нь алдарт эхийн одонтой эхчүүд бөгөөд 625.9 сая төг, 13.3% буюу 2548 нь насны хишиг тэтгэмж авч буй ахмадууд 444.9 сая төг, 22.8% буюу 4350 нь 0-3 насны хүүхдээ асарч буй эхчүүд болон олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эх, жирэмсэн эмэгтэйчүүдэд 1479.1 сая төг, нийгмийн халамжийн тэтгэмжийг 1845 иргэнд 1159.3 сая төгрөг, Халамжийн тэтгэврийг 806 иргэнд 1586.4 сая төгрөгийг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг 3035 иргэнд сая 389.3 төгрөгийн тусламжийг үзүүлсэн бол ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламжийг 1545 иргэнд 387.6 сая төгрөгийг, бусад төрлийн тусламж үйлчилгээнд 382 иргэнийг хамруулан 143.0 сая төгрөгийг зарцуулжээ.

## VII. Нийгмийн даатгал

Аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 2019 оны эхний 11 сарын байдлаар 32762.4 сая төгрөг, зарлага 30859.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 5762.0 сая төгрөгөөр өсч, зарлага 3758.9 сая төгрөг буюу 13.9 хувиар өслөө.

Аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалд 2019 оны эхний 11 сарын байдлаар 11052 хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 2429 хүн буюу 22.0 хувь нь аж ахуйн нэгж, байгууллагаас, 4179 хүн буюу 37.8 хувь нь төсөвт байгууллагаас, 4444 хүн буюу 40.2 хувь нь сайн дураар шимтгэл төлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж ахуй нэгж, байгууллагын даатгуулагч, сайн дурын даатгуулагч нар өссөн, төсөвт байгууллага буурсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2019 оны эхний 11 сарын байдлаар 26899.0 сая төг болж, үүний 83.6 хувийг өндөр настны, 10.4 хувийг хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн, 2.7 хувийг тэжээгчээ алдсаны, 3.3 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Энэ оны эхний 11 сарын байдлаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авагч 7151 хүн байна. Нийт тэтгэвэр авагчдын 82.5 хувь буюу 5901 хүн өндөр насны, 12.3 хувь буюу 878 хүн тахир дутуугийн, 3.3 хувь буюу 237 хүн тэжээгчээ алдсаны, 1.9 хувь буюу 135 хүн нь цэргийн тэтгэвэр авагчид байна.

Энэ оны эхний 11 сарын байдлаар тэтгэмжийн даатгалын сангаас тэтгэмж авагчид 2283, ҮОМШӨ-ний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авагчид 31 ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагч 214 хүн байна.

Эхний 11 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тоо 31789 байгаагийн 77.4 хувь буюу 24602 төр хариуцах иргэд, 15.2 хувь буюу 4845 малчид, 5.3 хувь буюу 1694 аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, 2.0 хувь буюу 648 оюутан суралцагсад байна.

2019 оны 11 сарын байдлаар аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 10678.6 сая төгрөг болж төлөвлөгөөгөө 24.4 хувиар буюу 2093.4 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөө бүх сумд давуулан биелүүлсэн байна.

## VIII. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 2019 оны 11-р сарын байдлаар 858 эх төрсөн ба нийт 867 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 26 тохиолдлоор өссөн байна. Нийт төрсөн хүүхдүүдийн 51.9 хувь нь эрэгтэй, 48.1 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Төрсөн эхчүүдийн 88.3 хувь нь аймгийн нэгдсэн эмнэлэгт төрсөн байна. Тус аймагт энэ оны байдлаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд, 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 6 гарсан байна. Нас баралтын 234 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 12 тохиолдлоор буурчээ. Нас баралтыг шалтгаанаар нь авч үзвэл хорт хавдрын нас баралт хамгийн өндөр буюу 28.2 хувийг эзэлж 66 хүн нас барсан байна.

Тухайн сарын байдлаар стационарит шинээр 9842 эмчлүүлэгч хэвтэж, 9836 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 69190 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7.0 байна. 2019 оны 11 сарын байдлаар 159984 амбулаторийн үзлэг

бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 32.7 %, амбулаторийн үзлэг 45.2%, идэвхтэй хяналт 16.4 %, гэрийн үзлэг 4.2 %- ийг эзэлж байна. Нийт үзлэгт хамрагдсан хүмүүсийн 35.67 хувь нь эрэгтэй, 64.33 хувь нь эмэгтэй хүн байна. Халдварт өвчний 340 тохиолдол бүртгэгдээд байгаа нь урьд оны мөн үеэс 11 тохиолдлоор өсч, 10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 72.9 болж өмнөх оны мөн үеэс 1.3 пунктээр өссөн байна.

## IX. Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ, үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нэг өрхийнхийг биш, нийт өрхөөр тооцсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна. Тус аймагт 2019 оны 11-р сарын байдлаар хэрэглээний үнийн индекс 2018 оны 11-р сартай харьцуулахад 6.5 хувиар өсжээ.

Хэрэглээний үнийн индекс 6.5 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундааны бүлэг 13.8 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодис 5.5 хувиар, хувцас бөс бараа гутлын бүлэг 6.0 хувь өссөн, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 8.5 хувиар өссөн, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 5.5 хувь, эм тариа эмчилгээний бүлэг 0.8 хувь өссөн ба тээврийн бүлэг 0.3 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

2019 оны 11 сарын байдлаар Сайнцагаан сумын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн бараа, бензин , дизель түлшний үнийг оруууллаа.

ХҮНСНИЙ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНЭ /7 хоногоор/

| № | Барааны нэр, төрөл | XI/06 | XI/13 | XI/20 | XI/27 |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гурил, 1-р зэрэг, кг | 1300 | 1300 | 1300 | 1300 |
| 2 | Хонины мах, кг | 5000 | 5500 | 6500 | 6500 |
| 3 | Үхрийн мах, кг | 0 | 0 | 0 | 0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **4** | Ямааны ястай мах, кг | 5000 | 5000 | 6000 | 6000 |
| **5** | Элсэн чихэр, кг | 1933 | 1930 | 1950 | 1950 |
| **6** | Цагаан будаа, кг | 2425 | 2420 | 2420 | 2420 |
| **7** | Шингэн сүү, л | 3500 | 3500 | 3500 | 3500 |
| **8** | Ноолуурын үнэ 1 кг | 55000 | 55000 | 60000 | 60000 |
| **9** | Бензин А-80, 1литр | 1810 | 1810 | 1810 | 1810 |
| **10** | Бензин А-92, 1литр | 1920 | 1920 | 1920 | 1920 |
| **11** | Дизель түлш 1 литр | 2320 | 2320 | 2320 | 2490 |

## X.Хөдөө аж ахуй



Аймгийн хэмжээгээр энэ оны 11 сарын байдлаар оны эхний төллөх насны хээлтэгч малын 77.8 Хувь буюу 1286.0 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төл 99.4 хувь буюу 1281.8 мянган төл бойжиж байна. өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төлөлсөн хээлтэгч 8.1 хувь, бойжсон төл 15.9 хувиар тус тус өссөн байна.

Аймгийн хэмжээнд энэ оны 10 сарын байдлаар 10171 толгой мал хорогдоод байна. Үүний 74.9 хувь нь ямаа, 22.1 хувь нь хонь, 3.0 хувийг бод малын хорогдол эзэлж байна. Нийт хорогдсон том малын 19.7 хувийг хээлтэгч мал эзэлж байна.



## XI. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 2019 оны 11 сарын байдлаар 8860.0 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 14.1 хувиар өссөн байна.

## XII. Гэмт хэрэг



Цагдаагийн хэлтсийн 2019 оны 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 212 болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.1 хувь болж буурсан байна. Гэмт хэрэгт холбогдогчдын тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 29.4 хувиар буурч 115 хүн холбогдоод байна. 2019 оны 11 сарын байдлаар танхайрах, булаалт, албан тушаалын гэмт хэрэг гараагүй байна. Өнгөрсөн оны мөн үеэс малын хулгайн хэрэг, залилан, , хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх, дээрэмдэх гэмт хэргүүд өссөн байна. Харин, хүнийг санаатай алах, бусдын бие мах бодид гэмтэл учруулах гэмт хэрэг, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, бусдын эд хөрөнгийн хулгайн гэмт хэрэг буурсан байна.

Бүртгэгдсэн нийт хэргүүдийг өнгөөр нь авч үзвэл 24.5 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 25.5 хувийг бусдын эд хөрөнгийн хулгайн хэрэг, 1.8 хувийг хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг, 7.5 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын эсрэг гэмт хэрэг, 0.9 хувийг дээрмийн хэрэг, 2.4 хувийг хүчингийн хэрэг, 14.6 хувийг малын хулгайн хэрэг, 8.5 хувийг залилангийн хэрэг, 14.2 хувийг бусад хэрэг тус тус эзэлж байна.

Нийт гэмт хэргийн 22.2 хувийг согтуугаар, 3.7 хувийг бүлэглэж, 7.5 хувийг хүүхэд оролцсон, 7.5 хувийг эмэгтэй хүн оролцон үйлдсэн, 3.7 хувийг гэр бүлийн хүчирхийллийн улмаас хэрэг эзэлж байна. 18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг аймгийн дүн 69 хүн байхад Дэрэн 80, Сайнцагаан 105, Цагаандэлгэр 129 байгаа нь гэмт хэрэг ихтэй сумдад орж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 503.7 сая төгрөг, түүний 30,8 хувь буюу 155.3 сая төгрөгийг нөхөн төлүүлээд байна. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 2.0 хувиар өсч, 50.8 хувь болсон байна.

## XIII. Байгаль орчин

### ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Энэ сарын агаарын температур ихэнх нутгаар ОЖД-с 1.0-1.5 градусаар дулаан байх төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхэн ба сүүлчээр хүйтний эрч бага зэрэг суларч шөнөдөө 17-22 градус, өдөртөө 6-11 градус хүйтэн байна. Гуравдугаар арав хоногийн дунд үеэр хүйтний эрч чангарч шөнөдөө 28-33 градус, өдөртөө 17-22 градус хүйтэн байна. Бусад хугацаанд шөнөдөө 24-29 градус, өдөртөө 14-19 градус градус хүйтэн байх төлөвтэй.

Энэ сард ихэнх нутгаар дунджийн орчим цас орох төлөвтэй.

Нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар цас орж, шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

Гуравдугаар арав хоногийн эхэн болон дунд үеэр бага зэргийн цас орох төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр зарим газраар 18-20 м/с хүрч ширүүсэх төлөвтэй.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим цас орох төлөвтэй байна.

Нэгдүгээр арав хоногийн сүүлчээр нутгийн хойд хэсгээр, хоёрдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар цас орох төлөвтэй.

Салхи нэгдүгээр арав хоногийн дунд болон сүүлчээр мөн хоёрдугаар арав хоногийн дунд үеэр 18-20 м/с хүрч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй

# I.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН МЭДЭЭ, мянган төгрөгөөр

2019.12.12

| Үзүүлэлт | мөр | 2018 XI | 2019 XI | | | 19/18 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төл | гүйц | хувь | хувь |
| Нийт орлого /тусламжийн дүн/ | 1 | 37566410.5 | 39412056.9 | 40133229.9 | 101.8 | 106.8 |
| А.УРСГАЛ ОРЛОГО | 2 | 6931266.8 | 6110882.3 | 7015465.1 | 114.8 | 101.2 |
| I.ТАТВАРЫН ОРЛОГО | 3 | 4321724.3 | 3732786.8 | 4229978.5 | 113.3 | 97.9 |
| 1.1 Хүн амын орлогын албан татвар | 4 | 3051607.4 | 2575200.3 | 2958190.8 | 114.9 | 96.9 |
| 1.1 Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогын татвар | 5 | 2755704.2 | 2617667.8 | 2954853.5 | 112.9 | 107.2 |
| Хувь хүний орлогын албан татварын буцаалт | 6 | -427269.9 | -378213.9 | -378123.9 | 100.0 | - |
| 1.2 үйл ажиллагааны орлого | 7 | 238209.3 | 290746.4 | 317958.8 | 109.4 | 133.5 |
| 1.3 Хөрөнгө борлуулсаны | 8 | 31735.5 | 45000.0 | 38267.4 | 85.0 | 120.6 |
| 1.5 Бусад татвар | 9 | 453228.3 | 0.0 | 25235.0 | - | 5.6 |
| 2.Хөрөнгийн татвар/ҮХХболон бүү/ | 10 | 119979.4 | 124113.6 | 98062.9 | 79.0 | 81.7 |
| 3. Авто тээврийн хэрэгслийн | 11 | 241439.5 | 302720.0 | 266899.4 | 0.0 | 110.5 |
| 4. Бусад татвар | 12 | 908698.0 | 730752.9 | 906825.4 | 124.1 | 99.8 |
| 4.1 Улсын тэмдэгтийн | 13 | 168720.8 | 173252.5 | 135253.0 | 78.1 | 80.2 |
| 4.2 Ашигт малтмал нөөцийн | 14 | 48449.2 | 48400 | 24106.1 | 49.8 | 49.8 |
| 4.3 Газрын төлбөр | 15 | 211144.5 | 230604.8 | 266015.9 | 115.4 | 126.0 |
| 4.5 Хог хаягдалын үйлчилгээний | 16 | 13709.8 | 85048.9 | 32561.5 | 38.3 | 237.5 |
| 4.6 Усны төлбөр | 17 | 44665.7 | 36446.7 | 33691.7 | 92.4 | 75.4 |
| 4.6.Бусад | 19 | 422008.0 | 157000.0 | 415197.2 | 264.5 | 98.4 |
| II.ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 20 | 2609542.5 | 2378095.5 | 2785486.6 | 117.1 | 101.6 |
| 2.1 Төсөвт байгууллагын өөрийн орлого | 21 | 2143785.6 | 1572155.9 | 1606993.2 | 102.2 | 75.0 |
| 2.2 Бусад нэр заагдаагүй | 22 | 465756.9 | 805939.6 | 1178493.4 | 146.2 | 253.0 |
| Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО | 23 | 36287.0 | 85250.0 | 29913.5 | 35.1 | 82.4 |
| В.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО | 24 | 30598856.7 | 33215924.6 | 33087851.3 | 99.6 | 108.1 |
| 1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг | 25 | 6516259.8 | 8906391.4 | 8906391.4 | 100.0 | 136.7 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 26 | 22260687.9 | 21205881.8 | 21205881.8 | 100.0 | 95.3 |
| Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгээс санхүүжих | 27 | 1821909.0 | 2823408.8 | 2824925.1 | 100.1 | 155.1 |
| Хандив тусламж | 28 | 0.0 | 280242.6 | 150653 | 53.8 | - |
| Орон нутгийн төсвийн орлого /тусламжийн орлого ороогүй / | 29 | 6967553.8 | 6196132.3 | 7045378.6 | 113.7 | 101.1 |
| Улсын төсөвт төвлөрүүлж байгаа орлого | 30 | 1742727.6 | 1795820.0 | 1990028.2 | 110.8 | 114.2 |
| Аймгийн нийт орлого | 31 | 8710281.4 | 7991952.3 | 9035406.8 | 113.1 | 103.7 |

## II.ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2019.12.12

| Сумд | 2019 I-XI | | | 2019 XI сар | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь | төлөвлөгөө | гүйцэтгэл | хувь |
| Дэлгэрцогт | 99550.5 | 102847.3 | 103.3 | 9020.0 | 11505.7 | 127.6 |
| Дэрэн | 115864.9 | 134521.0 | 116.1 | 10147.0 | 13321.1 | 131.3 |
| Говь-Угтаал | 292032.8 | 767475.9 | 262.8 | 37190.0 | 157326.8 | 423.0 |
| Цагаандэлгэр | 68830.8 | 72575.0 | 105.4 | 6826.1 | 10099.5 | 148.0 |
| Баянжаргалан | 598528.6 | 323106.5 | 54.0 | 111635.7 | 14501.1 | 13.0 |
| Өндөршил | 172995.5 | 208234.3 | 120.4 | 11790.0 | 10807.7 | 91.7 |
| Гурвансайхан | 345823.4 | 369584.6 | 106.9 | 40217.2 | 46757.4 | 116.3 |
| Өлзийт | 253344.8 | 302364.6 | 119.3 | 27180.0 | 15754.7 | 58.0 |
| Хулд | 204713.8 | 174933.4 | 85.5 | 18182.5 | 35126.5 | 193.2 |
| Луус | 130560.9 | 144398.2 | 110.6 | 11134.0 | 11699.4 | 105.1 |
| Дэлгэрхангай | 164100.7 | 259805.9 | 158.3 | 15914.0 | 45112.8 | 283.5 |
| Сайхан-Овоо | 122423.3 | 121309.4 | 99.1 | 11769.0 | 20379.0 | 173.2 |
| Эрдэнэдалай | 277846.3 | 291324.1 | 104.9 | 30952.6 | 22420.1 | 72.4 |
| Сайнцагаан | 705951.5 | 649598.9 | 92.0 | 61351.4 | 77070.2 | 125.6 |
| Адаацаг | 150035.6 | 202197.8 | 134.8 | 11796.4 | 24706.4 | 209.4 |
| Дундговь | 2763670.3 | 3221453.2 | 116.6 | 386893.6 | 295772.5 | 76.4 |
| Дүн | 6466273.7 | 7345730.1 | 113.6 | 801999.5 | 812360.9 | 101.3 |

## III.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ДҮН, сар бүрийн эцэст, мянган төгрөгөөр

2019.12.12

| Зарлагын төрөл | 2018 XI | 2019 XI | | | 2019 XI /2018 XI |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | |
| Орон нутгийн байгууллагын зарлагын дүн | 33666986.0 | 43396033.1 | 36413931.8 | 83.9 | 108.2 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 16793868.4 | 22367470.6 | 20644768.0 | 92.3 | 122.9 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2002911.3 | 2798080.2 | 2580099.6 | 92.3 | 128.8 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2849609.7 | 3875791.1 | 3523156.1 | 92.2 | 123.6 |
| Хангамж бараа материалын зардал | 662850.3 | 928281.3 | 756589.5 | 81.5 | 114.1 |
| Норматив зардал | 1096437.9 | 1571589.1 | 1176448.7 | 74.9 | 107.3 |
| Эд хогшил урсгал засварын зардал | 432854.3 | 596197.5 | 516403.0 | 86.6 | 119.3 |
| Томилолтын зардал | 135260.4 | 313941.5 | 279890.5 | 89.2 | 206.9 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 921251.1 | 1326166.6 | 1223366.1 | 92.2 | 132.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 1658078.0 | 2174339.0 | 2399592.3 | 110.4 | 144.7 |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 0.0 | 187369.2 | 187368.7 | 100.0 | - |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | 242050.6 | 0.0 | 0.0 | - | 0.0 |
| Бусад урсгал шилжүүлэг | 4371487.3 | 522673.8 | 439855.1 | 84.2 | 10.1 |
| Хөрөнгийн зардал | 2500326.7 | 4030617.5 | 2505894.2 | 62.2 | 100.2 |
| Эргэж төлөгдөх зээл | 0 | 2703515.7 | 180500 | 6.7 | - |

# IV.БАНКНЫ КАССЫН ОРЛОГО, ЗАРЛАГА, ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙН МЭДЭЭ, сар бүрийн эцэст, сая төгрөгөөр

2019.12.12

| Үзүүлэлт | | ХААН банк | | Хас банк | | Төрийн банк | | Капитал банк | | Бүгд | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2018 XI | 2019 XI | 2018 XI | 2019 XI | 2018 XI | 2019 XI | 2018 XI | 2019 XI | 2018 XI | 2019 XI | 2019/ 2018 хувь |
| Кассын орлого | Зузаатгалаар | 9,915.6 | 9,354.1 | 1198.9 | 88.6 | 8691.1 | 4862.6 | 0.0 | 0.0 | 19805.6 | 14305.3 | 72.2 |
| Кассын зарлага | шилжүүлсэн | 10,430.8 | 6,546.8 | 3449.1 | 3100.0 | 5669.0 | 4906.7 | 192.2 | 0.0 | 19741.1 | 14553.5 | 73.7 |
| Зээлийн өрийн үлдэгдэл | | 61921.6 | 59868.4 | 61756.2 | 12419.1 | 12197.7 | 38991.3 | 44099.3 | 0.0 | 111278.8 | 118053.2 | 106.1 |
| үүнээс: Анхаарал хандуулах зээл | | 231.2 | 271.4 | 316.2 | 287.4 | 901.8 | 119.3 | 265.2 | 0.0 | 678.1 | 1483.2 | 218.7 |
| | чанаргүй зээл | 403.1 | 378.1 | 399.4 | 579.0 | 596.1 | 87.1 | 265.4 | 0.0 | 1044.2 | 1260.9 | 120.8 |
| Нийт хадгаламжийн үлдэгдэл | | 34147.3 | 35457.9 | 44093.6 | 4158.2 | 4872.3 | 11051.3 | 15720.8 | 0.0 | 50667.4 | 64686.7 | 127.7 |

# V. АЙМГИЙН АЖИЛ ХАЙГЧ ИРГЭДИЙН МЭДЭЭ

2019.12.12

| Сум | Оны эхний хөдөлмөрийн насны хүн ам | Тайлант сарын эхэнд байсан ажилгүйчүүд | Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд | Үүнээс эмэгтэй | Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүйчүүд |
|---|---|---|---|---|---|
| Дэлгэрцогт | 1101 | 11 | 18 | 6 | 163 |
| Дэрэн | 1365 | 23 | 16 | 8 | 117 |
| Говь-Угтаал | 1057 | 41 | 52 | 26 | 492 |
| Цагаандэлгэр | 688 | 31 | 32 | 13 | 465 |
| Баянжаргалан | 800 | 32 | 13 | 2 | 163 |
| Өндөршил | 970 | 33 | 41 | 22 | 423 |
| Гурвансайхан | 1417 | 38 | 29 | 9 | 205 |
| Өлзийт | 1628 | 1 | 3 | 1 | 18 |
| Хулд | 1608 | 25 | 42 | 22 | 261 |
| Луус | 1255 | 28 | 28 | 12 | 223 |
| Дэлгэрхангай | 1475 | 32 | 23 | 11 | 156 |
| Сайхан-Овоо | 1442 | 31 | 33 | 21 | 229 |
| Эрдэнэдалай | 3708 | 69 | 66 | 35 | 178 |
| Сайнцагаан | 10057 | 76 | 92 | 47 | 91 |
| Адаацаг | 1899 | 44 | 14 | 10 | 74 |
| Дүн | 30470 | 515 | 502 | 245 | 165 |

# VI. АЖЛЫН БАЙРНЫ ЗУУЧЛАЛ, 2019 оны эхний 11 сарын байдлаар

2019.12.12

| Эдийн засгийн салбарын ангилал | Ажилд зуучилсан иргэд | үүнээс: эмэгтэй | Эдийн засгийн салбарын эзлэх хувь |
|---|---|---|---|
| ХАА, ан агнуур, ойн аж ахуй | 88.0 | 28.0 | 14.1 |
| Уул уурхай олборлох үйлдвэр | 97.0 | 13.0 | 15.6 |
| Боловсруулах аж  үйлдвэр | 1.0 | 1.0 | 0.2 |
| Цахилгаан эрчим хүч, хий, уур агааржуулалт | 4.0 | 0.0 | 0.6 |
| Усан хангамж, бохир ус, зайлуулах систем, хог | 0.0 | 0.0 | 0.0 |
| Барилга | 19.0 | 2.0 | 3.1 |
| Бөөний ба жижиглэн худалдаа | 7.0 | 4.0 | 1.1 |
| Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 1.0 | 0.0 | 0.2 |
| Зочид буудал, зоогийн газар | 0.0 | 0.0 | 0.0 |
| Мэдээлэл холбоо | 0.0 | 0.0 | 0.0 |
| Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 12.0 | 10.0 | 1.9 |
| Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 151.0 | 76.0 | 24.3 |
| Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа | 32.0 | 13.0 | 5.1 |
| Боловсрол | 55.0 | 35.0 | 8.8 |
| Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа | 22.0 | 21.0 | 3.5 |
| Урлаг, үзвэр, тоглоом наадам | 13.0 | 7.0 | 2.1 |
| Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 120.0 | 78.0 | 19.3 |
| Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бүгд | 622.0 | 288.0 | 100.0 |

# VII.НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН МЭДЭЭ, 2019 оны 11 сарын байдлаар

мян.төг

2019.12.12

| Халамжийн төрөл | хамрагдсан хүн | Мөнгөн дүн |
|---|---|---|
| **Нийгмийн халамжийн тэтгэвэр** | **806** | **1,586,420** |
| Ахмад настны тэтгэвэр | 45 | 80,190 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр | 546 | 941,843 |
| 16 насанд хүрсэн одой иргэний тэтгэвэр | | - |
| Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд | 215 | 564,386 |
| Өрх толгойлсон эх, эцгийн тэтгэвэр | | |
| **Нийгмийн халамжийн тэтгэмж** | **1,845** | **1,159,315** |
| *Асаргааны тэтгэмж* | **1,046** | **736,431** |
| *Бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа* | 29 | 27,562 |
| *Гэр бүлийн тухай хуулийн 25.5д заасан болон хүчирхийллийн* | 3 | 3,781 |
| *Тэжээн тэтгэх хүүхэдгүй ,ганц бие ахмад настан болон хөгжлийн* | **5** | **2,229** |
| *Ахмад настныг гэртээ асрамжилж байгаа иргэний* | 5 | 2,229 |
| *Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэртээ асрамжилж байгаа* | | |
| *Эмнэлгийн хяналтад байдаг ,байнгын асаргаа шаардлагатай ахмад* | **1,009** | **702,859** |
| *Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг* | 180 | 111,778 |
| *Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асарч байгаа* | 654 | 439,385 |
| *Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй* | 175 | 151,696 |
| *Нийгмийн халамжийн дэмжлэг ,туслалцаа шаардлагатай өрхийн гишүүн -* | | |
| **Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж мөр (66)=мөр (61:66)** | **799** | **422,884** |
| *Гэнэтийн аюул ,осол ,урьдчилан төсөөлөх боломжгүй бусад* | 26 | 38,400 |
| *18нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24насны* | 4 | 4,800 |
| *Хорих ангиас суллагдсан өөрийн гэсэн гэр оронгүй ,нийгмийн* | 2 | 2,400 |
| *Нийгмийн халамжийн дэмжлэг ,туслалцаа зайлшгүй* | | |
| *Байнгын асаргаа шаардлагатай 16хүртэл насны хүүхэд* | 174 | 285,034 |
| *Байнгын асаргаа шаардлагатай 16ба түүнээс дээш насны* | 593 | 92,250 |
| **Алдарт эхийн одонгийн мөнгөн тусламж** | **4564** | **625,900** |
| **Хүүхдийн мөнгөн тэтгэмж** | | |
| **Нийгмийн халамжийн үйлчилгээ** | **156** | **22,617** |
| **Нийгмийн хөгжлийн үйлчилгээ** | **3,035** | **389,344** |
| *Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ* | 3035 | 389,344 |
| *Боловсролыг дэмжих үйлчилгээ* | 0 | - |
| **Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт** | **1545** | **387,655** |
| **Алдар цолтон ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт** | **29** | **50,281** |
| **Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт** | **197** | **70,142** |
| **Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж** | **4350** | **1478295.5** |
| *0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж* | 2929 | 1155708 |
| *Жирэмсэн эхийн тэтгэмж* | 1263 | 171443.2 |
| *Ихэр хүүхдийн тэтгэмж* | **12** | **24,000** |
| *Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн* | **146** | **127,944** |
| **Насны хишиг** | **2548** | **444,900** |
| **Нийт** | 19,075 | 6,214,869 |

VIII. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО, ТЭТГЭВРИЙН САНХҮҮЖИЛТ,
2019 оны эхний 11 сарын байдлаар

2019.12.12

| Сумд | Н.Д.Шимтгэлийн орлого /мян.төг/ | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | төл | гүйц | хувь | олгох | олгосон | хувь |
| Дэлгэрцогт | 209274.6 | 250232.3 | 119.6 | 1110000.6 | 1110000.6 | 100.0 |
| Дэрэн | 194276.5 | 255490.1 | 131.5 | 1221607.1 | 1221607.1 | 100.0 |
| Говь-Угтаал | 225451.5 | 345671.7 | 153.3 | 961877.6 | 961877.6 | 100.0 |
| Цагаандэлгэр | 140030.6 | 187307.4 | 133.8 | 549386.5 | 549386.5 | 100.0 |
| Баянжаргалан | 220383.0 | 353930.5 | 160.6 | 582549.6 | 582549.6 | 100.0 |
| Өндөршил | 202812.3 | 271808.0 | 134.0 | 773228.8 | 773228.8 | 100.0 |
| Гурвансайхан | 302533.1 | 303118.2 | 100.2 | 1046003.3 | 1046003.3 | 100.0 |
| Өлзийт | 237133.5 | 332025.7 | 140.0 | 1352162.1 | 1352162.1 | 100.0 |
| Хулд | 272445.9 | 359340.0 | 131.9 | 1285911.0 | 1285911.0 | 100.0 |
| Луус | 248287.2 | 308990.2 | 124.4 | 1082187.2 | 1082187.2 | 100.0 |
| Дэлгэрхангай | 263773.5 | 352861.5 | 133.8 | 1240152.7 | 1240152.7 | 100.0 |
| Сайхан-Овоо | 196842.4 | 253134.5 | 128.6 | 1013662.4 | 1013662.4 | 100.0 |
| Эрдэнэдалай | 546330.7 | 713413.5 | 130.6 | 3199404.0 | 3199404.0 | 100.0 |
| Адаацаг | 257711.7 | 326280.4 | 126.6 | 1413886.2 | 1413886.2 | 100.0 |
| Сайнцагаан | 5067830.9 | 6064947.1 | 119.7 | 10143683.7 | 10143683.7 | 100.0 |
| Дүн | 8585117.4 | 10678551.1 | 124.4 | 26975702.8 | 26975702.8 | 100.0 |

# IX. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА,
## жил бүрийн эхний 11 сарын байдлаар

2019.12.12

/сая.төг/

| | | 2018 оны | XI сар | | 2019 оны XI сар Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| Нийгмийн даатгалын сангийн орлого | 27000.4 | 8585.1 | 32762.4 | 381.6 | 121.3 |
| Үүнээс | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 23493.1 | 7091.2 | 28747.2 | 405.4 | 122.4 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 1086.3 | 760.3 | 1240.2 | 163.1 | 114.2 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 1656.6 | 0.0 | 1885.2 | 0.0 | 113.8 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сангийн | 478.7 | 607.0 | 606.0 | 99.8 | 126.6 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 285.8 | 126.6 | 283.8 | 224.2 | 99.3 |
| Нийгмийн даатгалын сангийн зарлага | 27100.3 | 29449.3 | 30859.2 | 104.8 | 113.9 |
| Үүнээс | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сангийн | 23460.0 | 27392.1 | 26899.0 | 98.2 | 114.7 |
| Тэтгэмжийн даатгалын сангийн | 1122.7 | 1207.1 | 1214.9 | 100.6 | 108.2 |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн | 1762.4 | 0.0 | 1873.4 | 0.0 | 106.3 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сангийн | 470.0 | 536.2 | 594.9 | 110.9 | 126.6 |
| Ажилгүйдлийн даатгалын сангийн | 285.2 | 313.9 | 277.0 | 88.2 | 97.1 |

Тайлбар: *Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал

## X. НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧИЙН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ,
жил бүрийн эхний 11 сарын байдлаар

2019.12.12

| Үзүүлэлтүүд | 2017 оны XI сар | 2018 оны XI сар | 2019 оны XI сар | 2019 XI / 2018 XI хувь |
|---|---|---|---|---|
| Заавал даатгуулагчийн тоо | 10840 | 10875 | 11052 | 101.6 |
| Үүнээс: | | | | |
| Аж ахуйн нэгж, байгууллага | 2366 | 2421 | 2429 | 100.3 |
| Төсөвт байгууллага | 4128 | 4194 | 4179 | 99.6 |
| Сайн дурын | 4346 | 4260 | 4444 | 104.3 |
| Олгосон тэтгэвэр, сая төг | 20377.8 | 23460.0 | 26899.0 | 114.7 |
| Үүнээс: | | | | |
| Өндөр настны | 16760.0 | 19409.5 | 22483.9 | 115.8 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн | 2435.2 | 2558.4 | 2807.8 | 109.7 |
| Тэжээгчээ алдсаны | 596.3 | 657.7 | 727.7 | 110.6 |
| Цэргийн | 586.3 | 828.1 | 876.2 | 105.8 |

# XI. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨН ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ сумдаар

2019.12.12

| сумд | төрсөн хүүхдийн тоо | | Бүх нас баралт | | 0-1 насны хүүхдийн эндэгдэл | | 0-5 насны хүүхдийн эндэгдэл | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2018 | 2019 | 2018 | 2019 | 2018 | 2019 | 2018 | 2019 |
| Дэлгэрцогт | 2 | 2 | 9 | 10 | 1 | 0 | 1 | 1 |
| Дэрэн | 4 | 5 | 8 | 6 | 0 | 0 | 0 | 0 |
| Говь-Угтаал | 7 | 20 | 10 | 6 | 0 | 0 | 1 | 0 |
| Цагаандэлгэр | 0 | 2 | 4 | 3 | 0 | 0 | 1 | 0 |
| Баянжаргалан | 0 | 2 | 7 | 9 | 0 | 0 | 0 | 0 |
| Өндөршил | 4 | 2 | 4 | 6 | 0 | 0 | 0 | 0 |
| Гурвансайхан | 1 | 1 | 14 | 7 | 1 | 0 | 1 | 0 |
| Өлзийт | 4 | 9 | 7 | 7 | 0 | 0 | 0 | 0 |
| Хулд | 4 | 1 | 10 | 8 | 1 | 0 | 1 | 0 |
| Луус | 3 | 3 | 9 | 10 | 0 | 0 | 0 | 0 |
| Дэлгэрхангай | 10 | 15 | 19 | 16 | 1 | 0 | 1 | 0 |
| Сайхан-Овоо | 3 | 5 | 6 | 13 | 0 | 0 | 0 | 0 |
| Эрдэнэдалай | 21 | 26 | 26 | 36 | 0 | 2 | 0 | 2 |
| Сайнцагаан | 763 | 758 | 98 | 81 | 2 | 3 | 5 | 3 |
| Адаацаг | 8 | 7 | 15 | 16 | 1 | 1 | 1 | 2 |
| Дүн | 834 | 858 | 246 | 234 | 7 | 6 | 12 | 8 |

XII. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 11 сарын байдлаар

2019.12.12

| Сумд | Хэвтэж эмчлүүлсэн хүний тоо | | Бүгд үзлэг | | Бүртгэгдсэн бүх өвчлөл | | Халдварт өвчин бүгд | | үүнээс /зарим үзүүлэлтээр/ | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | сүрьеэ | | вируст гепатит | |
| | 2018 | 2019 | 2018 | 2019 | 2018 | 2019 | 2018 | 2019 | 2018 | 2019 | 2018 | 2019 |
| Дц | 235 | 284 | 1819 | 1754 | 239 | 290 | 25 | 8 | 1 | | | |
| Дн | 174 | 149 | 2616 | 1524 | 308 | 419 | 7 | 6 | 2 | 1 | | |
| Гу | 176 | 227 | 3745 | 3426 | 359 | 1781 | 9 | 12 | 2 | 1 | | |
| Цд | 163 | 145 | 2030 | 1186 | 307 | 223 | 1 | 2 | | | | |
| Бж | 167 | 203 | 2536 | 1792 | 287 | 220 | 2 | 1 | | | | |
| Өш | 214 | 252 | 3427 | 2818 | 244 | 337 | 6 | 0 | 1 | | | |
| Гс | 152 | 139 | 3183 | 2970 | 503 | 554 | 10 | 12 | 1 | 1 | | |
| Өт | 135 | 109 | 3819 | 3108 | 216 | 281 | 10 | 20 | | 2 | 2 | 1 |
| Хд | 177 | 174 | 2577 | 1285 | 210 | 633 | 7 | 13 | 3 | 2 | 1 | 1 |
| Лс | 209 | 214 | 2494 | 3563 | 152 | 183 | 11 | 5 | | 1 | 2 | |
| Дх | 114 | 171 | 3608 | 1915 | 87 | 92 | 4 | 7 | | 1 | | |
| Со | 182 | 155 | 1842 | 904 | 839 | 432 | 6 | 2 | 2 | | 1 | |
| Эд | 508 | 487 | 8858 | 10546 | 1026 | 2097 | 4 | 16 | | 4 | | |
| Ад | 243 | 287 | 7762 | 3249 | 486 | 392 | 8 | 12 | 3 | 3 | 2 | |
| Сц | 5613 | 5185 | 106488 | 117290 | 15252 | 22657 | 219 | 224 | 16 | 9 | 3 | |
| Мд | 403 | 416 | 421 | 370 | 0 | 0 | 0 | 0 | | | | |
| Эб | 377 | 384 | 282 | 403 | 0 | 0 | 0 | 0 | | | | |
| МУЭ төв | 882 | 855 | 2107 | 1881 | 508 | 586 | 0 | 0 | | | | |
| ДҮН | 10124 | 9836 | 159614 | 159984 | 21023 | 31177 | 329 | 340 | 31 | 25 | 11 | 2 |

* Эрүүл мэндийн газрын мэдээгээр

# XIII. ДУНДГОВЬ АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

2019.12.12

| . | 2019 XI<br>2018 XI | 2019 XI<br>2018 XII |
|---|---|---|
| ЕРӨНХИЙ ИНДЭКС | 106.5 | 105.9 |
| 01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА | 113.8 | 111.7 |
| 01.1 ХҮНСНИЙ БАРАА | 115.1 | 112.8 |
| 01.1.1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА | 117.4 | 116.2 |
| 01.1.2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН | 121.6 | 116.8 |
| 01.1.3 ЗАГАС, ДАЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН | 122.7 | 122.7 |
| 01.1.4 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ | 96.9 | 92.8 |
| 01.1.5 ТӨРӨЛ БҮРИЙН ӨӨХ, ТОС | 103.0 | 103.0 |
| 01.1.6 ЖИМС, ЖИМСГЭНЭ | 123.1 | 123.1 |
| 01.1.7 ХҮНСНИЙ НОГОО | 117.6 | 113.8 |
| 01.1.8 СААХАР, ЖИМСНИЙ ЧАНАМАЛ, ЗӨГИЙН БАЛ, ЧИХЭР | 103.8 | 102.6 |
| 01.1.9 ХҮНСНИЙ БУСАД БҮТЭЭГДЭХҮҮН | 107.1 | 105.9 |
| 01.2 СОГТУУРУУЛАХ БУС УНДАА | 99.4 | 98.8 |
| 02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС | 105.5 | 104.8 |
| 02.1 СОГТУУРУУЛАХ УНДАА | 105.7 | 104.7 |
| 02.2 ТАМХИ | 105.1 | 105.1 |
| 03. ХУВЦАС, БӨС БАРАА ГУТАЛ | 106.0 | 106.0 |
| 03.1 ХУВЦАС, БӨС БАРАА | 107.3 | 107.3 |
| 03.1.1 ХӨВӨН, БӨС БАРАА | 115.1 | 115.1 |
| 03.1.2 БҮХ ТӨРЛИЙН ХУВЦАС | 106.5 | 106.5 |
| 03.1.3 ЖИЖИГ ЭДЛЭЛ, ХЭРЭГСЭЛ | 101.5 | 101.5 |
| 03.2 ГУТАЛ | 103.1 | 103.1 |
| 04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ | 108.5 | 107.0 |
| 04.1 ОРОН СУУЦНЫ БОДИТ ТҮРЭЭС | 100.0 | 100.0 |
| 04.2 ОРОН СУУЦНЫ ТЕХНИКИЙН БОЛОН ЗАСВАРЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 107.2 | 107.0 |
| 04.3 УСАН ХАНГАМЖ БОЛОН ОРОН СУУЦНЫ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| 04.5 ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ | 110.4 | 108.1 |

| Барааны бүлгээр | 2019 XI / 2018 XI | 2019 XI / 2018 XII |
|---|---|---|
| **05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА** | **105.5** | **105.0** |
| 05.1 ГЭР АХУЙН ТАВИЛАГ, ХЭРЭГСЭЛ, ХИВС БОЛОН ШАЛНЫ БУСАД ДЭВСГЭР | 105.7 | 105.7 |
| 05.2 ГЭР АХУЙН ОЁМОЛ, НЭХМЭЛ ЭДЛЭЛ | 106.4 | 106.4 |
| 05.3 ГЭР АХУЙН ЦАХИЛГААН БАРАА | 102.0 | 102.0 |
| 05.4 ГЭР АХУЙН ШИЛЭН ЭДЛЭЛ, САВ СУУЛГА | 108.7 | 108.7 |
| 05.5 ГЭР АХУЙ, ЦЭЦЭРЛЭГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨДӨЛМӨРИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛ | 100.3 | 100.3 |
| 05.6 ГЭР АХУЙН ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ БОЛОН БУСАД ЖИЖИГ БАРАА ГЭРИЙН БУСАД | 106.9 | 105.0 |
| **06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | **100.8** | **100.8** |
| 06.1 ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙНИ ХЭРЭГСЭЛ | 100.9 | 100.9 |
| 06.2 АМБУЛТОРЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| 06.3 ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ҮЗҮҮЛСЭН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| **07. ТЭЭВЭР** | **99.7** | **99.8** |
| 07.1 ТЭЭВРИЙН ХЭРГСЭЛИЙН ХУДАЛДАН АВАЛТ | 101.9 | 101.9 |
| 07.2 ХУВИЙН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ | 96.3 | 96.5 |
| 07.3 ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 101.2 | 101.2 |
| **08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ** | **100.0** | **100.0** |
| 08.2 ТЕЛЕФОН АППАРАТ, ФАКСЫН ХЭРЭГСЭЛ | 100.0 | 100.0 |
| 08.3 ТЕЛЕФОН УТАС, ФАКСЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |
| **09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА ҮЙЛЧИЛГЭЭ** | **103.4** | **103.3** |
| 09.1 ДУУ, ДҮРС, ГЭРЭЛ ЗУРАГ, МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ТОНОГ ТӨХӨӨРӨМ | 102.3 | 102.3 |
| 09.2 ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.3 | 100.3 |
| 09.3 НОМ, СОНИН, БИЧГИЙН ХЭРЭГСЭЛ | 106.6 | 106.3 |
| **10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ** | **111.4** | **111.4** |
| **11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ** | **112.5** | **112.5** |
| 11.1 НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ | 114.8 | 114.8 |
| 11.2 ЗОЧИД БУУДАЛ ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ | 111.1 | 111.1 |
| **12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ** | **105.1** | **105.1** |
| 12.1 ХУВЬ ХҮНД ХАНДСАН ҮЙЛЧИЛГЭЭ | 105.6 | 105.6 |
| 12.3 ХУВЬ ХҮНИЙ ЭД ЗҮЙЛ, ХЭРЭГЛЭЛ | 105.1 | 105.1 |
| 12.5 ДААТГАЛ | 100.0 | 100.0 |
| 12.6 САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | 100.0 | 100.0 |

XIV. АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ (оны үнээр )

2019.12.12 мян.төг

| Аж үйлдвэрийн салбар | 2018 | 2019 | 2019/2018 хувь |
|---|---|---|---|
| **Нийт дүн** | **7765163.5** | **8859967.9** | **114.1** |
| **Уул уурхайн олборлох аж үйлдвэр** | **2961109.1** | **4508351.0** | **152.3** |
| Нүүрс олборлолт | 306290.1 | 301456.0 | 98.4 |
| Гөлтгөнө | 503944.0 | 2174395.0 | 431.5 |
| Жонш олборлолт | 2150875.0 | 2032500.0 | 94.5 |
| **Боловсруулах аж үйлдвэр** | **1127944.4** | **1150758.2** | **102.0** |
| Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл | 873558.0 | 924337.5 | 105.8 |
| Хуснэгт маягт үйлдвэрлэл | 20257.9 | 20267.8 | 100.0 |
| Боловсруулах үйлдвэр бусад | 234128.5 | 206152.9 | 88.1 |
| **Цахилгаан дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж** | **3676110.0** | **3200858.7** | **87.1** |
| *Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл* | 3064227.1 | 2518205.5 | 82.2 |
| Ус ариутгал ус хангамж | 611882.9 | 682653.2 | 111.6 |

# XV. ГОЛ НЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ

2019.12.12

| Гол нэр төрлийн бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | 2018 оны мөн үед | 2019 онд | 2019/2018 хувь |
|---|---|---|---|---|
| Хүрэн нүүрс | мян.тн | 10.7 | 10.6 | 99.1 |
| Жонш | мян.тн | 8.5 | 5.5 | 64.7 |
| Гөлтгөнө | мян.тн | 19.9 | 16.1 | 80.9 |
| Дулааны эрчим хүч | мян.гкал | 71.8 | 49.9 | 69.5 |
| Хүснэгт, маягт | х.д.х | 289.2 | 289.5 | 100.1 |
| Талх | тн | 116.9 | 136.6 | 116.9 |
| Нарийн боов | тн | 98.2 | 112.4 | 114.5 |
| Чихэр | тн | 2.9 | 1.9 | 65.5 |
| Архи | мян.л | 26.4 | 23.5 | 89.0 |
| Хиамны зүйл | тн | 0.6 | 0.5 | 83.3 |
| Сүү, тараг | мян.л | 5.3 | 8.8 | 166.0 |
| Хоормог | мян.л | 0.4 | 0.2 | 50.0 |
| Ааруул | тн | 0.5 | 0.9 | 180.0 |
| Вакум цонх | $м^2$ | 207.0 | 325.0 | 157.0 |
| Вакум хаалга | $м^2$ | 57.0 | 99.0 | 173.7 |
| Модон эдлэл | мян.төг | 138815.0 | 87418.9 | 63.0 |
| Түгээсэн цэвэр ус | мян.$т^3$ | 109.0 | 125.7 | 115.3 |
| Сувагжуулалт | мян.$м^3$ | 76.1 | 83.3 | 109.5 |
| Оёдол эсгүүр | мян.төг | 52542.0 | 25185.0 | 47.9 |
| Блок | мян.ш | 7.2 | 5.4 | 75.0 |

XVI. ХАА-н бүтээгдэхүүний үнийн мэдээ

2019.12.12

| | Хэмжих нэгж | | 2018 оны 1 сар | 2019 он | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1 р сар | 2 р сар | 3 р сар | 4 р сар | 5 р сар | 6 р сар | 7 р сар | 8 р сар | 9 р сар | 10 р сар | 11 р сар |
| 1. Малын үнэ /мян.төг/ | | | | | | | | | | | | | | |
| Тэмээ | | | | | | | | | | | | | | |
| Нас гүйцсэн | эр | тол | 1,103.8 | 1,215.4 | 1184.6 | 1183.3 | 1216.7 | 1303.8 | 1237.5 | 1288.5 | 1273.1 | 1234.6 | 1230.6 | 1291 |
| | эм | тол | 920.8 | 1,008.3 | 981.8 | 1008.3 | 1025 | 1054.2 | 1034.5 | 1084.5 | 1054.6 | 1050 | 1234.6 | 1072.2 |
| Өсвөр насны | эр | тол | 645.8 | 725.0 | 740.0 | 733.3 | 750 | 772.7 | 777.3 | 791 | 800 | 776.9 | 781.8 | 758.3 |
| | эм | тол | 633.3 | 704.2 | 735.0 | 720.8 | 736.4 | 757.3 | 761.8 | 771 | 761.8 | 740 | 768.2 | 745.8 |
| Адуу | | | | | | | | | | | | | | |
| Нас гүйцсэн | эр | тол | 736.7 | 860.0 | 807.1 | 853.6 | 884.6 | 888.5 | 892.3 | 892.3 | 935 | 925 | 930 | 973.3 |
| | эм | тол | 639.3 | 776.9 | 754.2 | 796.2 | 825 | 835.0 | 840 | 830.8 | 834 | 842.3 | 878.6 | 907.1 |
| Өсвөр насны | эр | тол | 482.7 | 634.6 | 600.0 | 596.2 | 627.5 | 637.5 | 620.8 | 627.5 | 635.8 | 645 | 673.1 | 682.1 |
| | эм | тол | 472.3 | 596.2 | 563.6 | 565.4 | 598.3 | 605.8 | 589.2 | 589.2 | 610 | 620.8 | 661.5 | 673.1 |
| Үхэр | | | | | | | | | | | | | | |
| Нутгийн үүлдрийн, нас гүйцсэн | эр | тол | 976.7 | 1,136.6 | 1100.0 | 1146.4 | 1272.2 | 1275 | 1257.7 | 1307.7 | 1246.4 | 1157.1 | 1180.8 | 1214.3 |
| | эм | тол | 871.4 | 984.6 | 953.8 | 965.4 | 1008.3 | 1037.5 | 1029.2 | 1054.5 | 1030.8 | 1026.9 | 1011.5 | 1073.8 |
| Өсвөр насны | эр | тол | 603.6 | 796.2 | 791.7 | 792.3 | 820.8 | 835 | 1029.2 | 866.4 | 851.7 | 814.3 | 836.4 | 834.6 |
| | эм | тол | 589.3 | 756.2 | 766.7 | 757.7 | 787.5 | 816.7 | 830.8 | 818.2 | 800 | 794.2 | 825.4 | 836.4 |
| Бог мал | | | | | | | | | | | | | | |
| Нас гүйцсэн хонь | эр | тол | 137.3 | 158.7 | 160.0 | 165.5 | 173.3 | 177.3 | 172.7 | 174.7 | 173.8 | 175.7 | 166 | 163.3 |
| | эм | тол | 97.9 | 112.3 | 108.3 | 113.8 | 120 | 126.2 | 124.6 | 123.5 | 123.8 | 121.4 | 117.3 | 110.7 |
| Нас гүйцсэн ямаа | эр | тол | 131.3 | 120.7 | 127.4 | 130 | 130.8 | 132.1 | 137.1 | 134.3 | 141.3 | 140 | 140.6 | 133.3 |
| | эм | тол | 95.4 | 90.4 | 92.1 | 87.3 | 92.1 | 96.3 | 98.7 | 93.8 | 101.9 | 98.2 | 101.3 | 88.9 |
| 2.Малын гаралтай бүтээгдэхүүний үнэ/мян.төг/ | | | | | | | | | | | | | | |
| Тэмээний ноос | | кг | - | - | | | | 4 | 5 | | 5.5 | | | |
| Ямааны ноолуур | | кг | - | - | | 122.0 | 108 | 85 | 80 | 82 | 82 | | | |
| Тэмээний шир | | ш | 18.0 | 15.0 | 17.0 | 20.0 | | | | | | | | 15 |
| Адууны шир | | ш | 20.0 | 10.0 | 9.0 | 10.0 | | | | 5 | 5 | 8 | 8 | 6 |
| -2 м-ээс доош хэмжээтэй үхрийн шир | | ш | 25.0 | - | | 0.0 | | | | | | | 5 | 5 |
| -2 м- ээс дээш хэмжээтэй үхрийн шир | | ш | 30.0 | - | | 0.0 | | | | | | | 5 | |
| Хонины ноостой, өлөн гэдэстэй арьс | | ш | 5.5 | 2.0 | | 0.0 | 1.5 | 1.5 | 1.5 | 2 | 2 | 3 | 3 | 2.5 |
| Ямааны ноолууртай, өлөнтэй арьс | | ш | 36.0 | 40.0 | 42.0 | 42.0 | | | | 0 | 0 | 2 | 12 | 30 |

## XVII. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ 11-Р САРЫН ҮНИЙН МЭДЭЭ/аймгаар/

2019.12.12

| | Нэр төрөл | Дундговь | Төв | Өмнөговь | Дорноговь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гурил, дээд зэрэг /Алтантариа/ | 1583.0 | 1406.0 | 1567.0 | 1433.0 |
| 2 | Гурил, 1-р зэрэг /Алтантариа/ | 1300.0 | 1210.0 | 1360.0 | 1133.0 |
| 3 | Гурил, 2-р зэрэг /Алтантариа/ | 975.0 | 870.0 | 1200.0 | 925.0 |
| 4 | Гоймон, /Алтан тариа/, туузан 320 г-тай | 850.0 | 750.0 | 1750.0 | 817.0 |
| 5 | Талх, орон нутгийн үйлдвэрийн | 1150.0 | 1283.0 | 1217.0 | 1500.0 |
| 6 | Гурилан боов,0.450г, /аймгийн үйлдвэрийн/ | 3250.0 | 1300.0 | 2400.0 | 2067.0 |
| 7 | Жигнэмэг /Юбилейные 150-180г, цайны/ | 1250.0 | 1267.0 | 1267.0 | 1250.0 |
| 8 | Цагаан будаа, задгай, кг | 2425.0 | 2367.0 | 2267.0 | 2267.0 |
| 9 | Шар будаа, задгай, кг | 3325.0 | 2950.0 | 3140.0 | 3233.0 |
| 10 | Хонины мах, кг | 6500.0 | 7833.0 | 6750.0 | 6500.0 |
| 11 | Адууны мах, кг | 8000.0 | 8000.0 | 7250.0 | 8167.0 |
| 12 | Ямааны мах, кг | 6000.0 | 6500.0 | 6250.0 | 5500.0 |
| 13 | Дотор мах, цувдай, цусгүй | 2000.0 | 2000.0 | 2750.0 | 2500.0 |
| 14 | Хиам чанасан, 1кг | 9550.0 | 11854.0 | 10500.0 | 8100.0 |
| 15 | Сүү, задгай, л | 3500.0 | 1333.0 | 3500.0 | 2000.0 |
| 16 | Сүү савласан,1л. Цэвэр сүү | 2900.0 | 2866.0 | 2890.0 | 2867.0 |
| 17 | Хорхой ааруул, задгай, чихэртэй | 28000.0 | 16500.0 | 15000.0 | 16000.0 |
| 18 | Өндөг,ш,дотоод | 380.0 | 360.0 | 350.0 | 350.0 |
| 19 | Ургамлын тос, 1литр, Кларина | 3700.0 | 3906.0 | 3350.0 | 3200.0 |
| 20 | Өөхөн тос, кг | - | 1400.0 | - | 1500.0 |
| 21 | Шар тос, кг | 20000.0 | 20000.0 | 18000.0 | 18000.0 |
| 22 | Цөцгийн тос, задгай, кг | - | 4000.0 | 3850.0 | 3500.0 |
| 23 | Төмс дотоод, кг | 1100.0 | 780.0 | 1450.0 | 833.0 |
| 24 | Лууван хятад, кг | 1350.0 | 1533.0 | 1450.0 | 1533.0 |
| 25 | Байцаа хятад, кг | 1600.0 | 1533.0 | 1200.0 | 1600.0 |
| 26 | Сонгино хятад, кг | 1650.0 | 1700.0 | 1600.0 | 1633.0 |
| 27 | Элсэн чихэр, кг, орос | 1950.0 | 1900.0 | 2100.0 | 2000.0 |
| 28 | Хатуу чихэр, орос, кг, /Барбарис/ | 5650.0 | 5366.0 | 3720.0 | 5567.0 |
| 29 | Зөөлөн чихэр, /Мишка/, кг | - | - | - | 9750.0 |
| 30 | Шоколад, "Alpen gold" | 2500.0 | 2466.0 | 2323.0 | 2300.0 |
| 31 | Давс, цагаан, 1 кг, йоджуулсан | 1100.0 | 996.0 | 833.0 | 750.0 |
| 32 | Майноз, /Золотой 500г/ | - | 5000.0 | 3797.0 | 4900.0 |
| 33 | Кетчуп, 900г, Чили Полиш | 2000.0 | 1900.0 | 2050.0 | 2000.0 |
| 34 | Ногоон цай, Stimo, савласан 90г | 0.0 | 1720.0 | 1413.0 | - |
| 35 | Байхуу цай, Акбар, 20 ширхэгтэй | 1675.0 | 1733.0 | 1597.0 | 1600.0 |
| 36 | Цагаан архи, 0.5 Ерөөл | 8650.0 | 8740.0 | 8733.0 | 9133.0 |
| 37 | Пиво, "Боргио", 0.5л | 1700.0 | 1766.0 | 1750.0 | 1800.0 |
| 38 | Янжуур тамхи, /West/, саарал | 3067.0 | 2866.0 | 2933.0 | 2700.0 |
| 39 | Янжуур тамхи, /Улаан шонхор/,Монгол тамхи | 2167.0 | 2043.0 | 2133.0 | 1900.0 |
| 40 | Бензин, А-80, 1 литр | 1810.0 | 1740.0 | 1850.0 | 1810.0 |
| 41 | Бензин, А-92, 1 литр | 1920.0 | 1773.0 | 1960.0 | 1910.0 |
| 42 | Дизель түлш, 1 литр | 2320.0 | 2303.0 | 2590.0 | 2560.0 |

# XVIII. ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ

2019.12.12

| сум | 18 ба түүнээс дээш насны хүн | 18 -аас дээш насны 10000 хүнд ноогдох | Бүх хэрэг | Холбогдогч | Хохирол /мян.төг/ | Зодлой үхэл | Хүн амь | хүчин | дээрэм | булаалт | танхай | бусдын бие махбодьд гэмтэл учруулсан | бусдын өмчийн хулгай | малын хулгай | Тээврийн хэрэгс-лийн хөдөлгөөний аюулгүй байдлын | гал түймэр | албан тушаал | Залилан | бусад |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Адаацаг | 1897 | 63 | 12 | 3 | 21175.2 | | | 1 | | | | | 7 | 2 | 1 | | | | 1 |
| Баянжаргалан | 819 | 49 | 4 | 1 | 5500.0 | | | | | | | 1 | 1 | | 1 | | | 1 | |
| Говь-Угтаал | 1058 | 57 | 6 | 5 | 30625.1 | | | | | | | 2 | 3 | 1 | | | | | |
| Гурвансайхан | 1424 | 70 | 10 | 2 | 16500.0 | | | | | | | 1 | 4 | 1 | | | | 1 | 3 |
| Дэлгэрхангай | 1483 | 61 | 9 | 5 | 28345.0 | | 1 | | | | | 3 | 1 | 1 | | | | 1 | 2 |
| Дэлгэрцогт | 1129 | 71 | 8 | 4 | 22500.0 | | | | | | | 2 | | 4 | 2 | | | | |
| Дэрэн | 1380 | 80 | 11 | 1 | 59141.0 | | | | | | | | 4 | 5 | 1 | | | 1 | |
| Луус | 1231 | 73 | 9 | 8 | 23340.0 | | | | | | | 2 | 3 | 2 | 1 | | | | 1 |
| Өлзийт | 1595 | 38 | 6 | 9 | 8000.0 | | | 1 | | | | 3 | | 1 | | | | | 1 |
| Өндөршил | 969 | 52 | 5 | 3 | 9000.0 | | 1 | | | | | 3 | 1 | | | | | | |
| Сайнцагаан | 10209 | 105 | 107 | 44 | 238047.0 | | 2 | 1 | 2 | | | 28 | 25 | 12 | 9 | | | 14 | 14 |
| Сайхан-Овоо | 1426 | 7 | 1 | 2 | 480.0 | | | | | | | 1 | | | | | | | |
| Хулд | 1576 | 44 | 7 | 3 | 10000.0 | | | 1 | | | | 1 | 2 | | | | | | 3 |
| Цагаандэлгэр | 699 | 129 | 9 | 3 | 12200.0 | | | 1 | | | | 2 | 1 | 1 | | | | | 4 |
| Эрдэнэдалай | 3721 | 21 | 8 | 4 | 18800.0 | | | | | | | 3 | 2 | 1 | 1 | | | | 1 |
| Бусад | 0 | | | 18 | | | | | | | | | | | | | | | |
| Бүгд | 30616 | 69 | 212 | 115 | 503653.3 | 0 | 4 | 5 | 2 | 0 | 0 | 52 | 54 | 31 | 16 | 0 | 0 | 18 | 30 |

# XIX. ГЭМТ ХЭРГИЙН МЭДЭЭ

2019.12.12

| | Үзүүлэлт | 2018 XI | 2019 XI | 19/18 хувь |
|---|---|---|---|---|
| | Оны эхний 18-аас дээш насны хүний тоо | 30528 | 30616 | 101.6 |
| | Бүх хэрэг | 262 | 212 | 80.9 |
| Хэргийн өнгө | Хүнийг санаатай алах гэмт хэрэг | 4 | 0 | 0.0 |
| | Хүчиндэх гэмт хэрэг | 6 | 5 | 83.3 |
| | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | 0 | 4 | 0.0 |
| | Дээрэмдэх гэмт хэрэг | 1 | 2 | 0.0 |
| | Булаалт | 0 | 0 | 0.0 |
| | Танхайн хэрэг | 0 | 0 | 0.0 |
| | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | 77 | 52 | 67.5 |
| | Бусдын эд хөрөнгийн хулгай | 103 | 54 | 52.4 |
| | Малын хулгай | 18 | 31 | 172.2 |
| | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг хэрэг | 16 | 16 | 100.0 |
| | Залилангийн хэрэг | 10 | 18 | 180.0 |
| | Албан тушаал | 0 | 0 | 0.0 |
| | Бусад | 27 | 30 | 111.1 |
| нөхцөл | Эмэгтэй хүн оролцсон | 12 | 16 | 133.3 |
| | Согтуугаар | 41 | 47 | 114.6 |
| | Бүлэглэж | 22 | 13 | 59.1 |
| | Хүүхэд оролцсон | 12 | 16 | 133.3 |
| | Илрээгүй хэрэг | 120 | 98 | 81.7 |
| | Гэр бүлийн хүчирхийллийн улмаас | 8 | 8 | 100.0 |
| хэргийн ангилал | Хөнгөн | 166 | 170 | 102.4 |
| | Хүндэвтэр | 0 | 0 | 0.0 |
| | Хүнд | 96 | 42 | 43.8 |
| | Онц хүнд | 0 | 0 | 0.0 |
| | Гэмт хэрэгт холбогдогсод | 163 | 115 | 70.6 |
| | Учирсан бүх хохирол /сая.төг/ | 834.0 | 503.7 | 60.4 |
| | Нөхөн төлүүлсэн хохирол /сая.төг/ | 269.2 | 155.3 | 57.7 |
| | Илрүүлэлтийн хувь | 49.8 | 50.8 | 102.0 |
| | 18 аас дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /аймаг/ | 86 | 69 | 80.7 |

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

**www.1212.mn**

**Дундговь аймгийн статистикийн хэлтэс**

**www.dundgovi.nso.mn**

Материалыг бэлтгэсэн:

Т.Бямбасүрэн
С.Доржханд
Н.Түвшинжаргал
Г.Ариунжаргал

Утас: 70593714, 70593715

2019 оны 12 сарын 12

СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН

ДАРГА Б.ЭНХТУЯА